



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: О.Алтансүвд

Утас: 88009224

Цахим хаяг: altansuvdo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.01.24 № 845
талаа _____ -ны № _____ -т

ОТГОН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТ-ОРГИЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд татвар болон татварын бус орлого 154,476.7 мянган төгрөгөөр, орон цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 207,317.5 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 106,433.5 мянган төгрөгөөр, улсын төсөвт байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт 17,580.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Отгон сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 390,014.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 581,035.2 мянган төгрөг буюу 148.9 хувиар давсан байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 22,159.7 мянган төгрөгийг 22 иргэнд буцаан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	787,146.32	752,757.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	527,286.70	553,887.87
33	АВЛАГА	204,632.75	86,391.17
35	БАРАА МАТЕРИАЛ	55,226.87	112,478.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	940,183.03	1,078,561.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	940,183.03	1,078,561.45
39200	Биет хөрөнгө	936,107.03	1,070,875.45
39300	Биет бус хөрөнгө	4,076.00	7,686.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,727,329.35	1,831,318.82
41360	Бусад өглөг	6,100.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,721,229.35	1,831,318.82
51	Засгийн газрын хувь оролцоо	1,721,229.35	1,831,318.82
51100	Засгийн газрын оруулсан капитал	782,776.19	782,776.19
51200	Хуримтлагдсан үр дүн	726,037.40	836,126.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,415.76	212,415.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,727,329.35	1,831,318.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,814,344.30	2,265,797.98
11	ТАТВАРЫН ОРЛОГО	333,291.74	425,471.70
110	Орлогын албан татвар	152,367.51	368,330.37
1100	Хувь хүний орлогын албан татвар	173,000.72	390,490.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,633.21	-22,159.73
113	Хөрөнгийн албан татвар	47,647.14	49,520.08
118	Бусад татвар, төлбөр, хураамж	133,277.10	7,621.26
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,057.62	3,603.57
1181	Газрын төлбөр	4,939.48	4,017.69
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	125,280.00	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	449,670.80	378,121.78
120	Нийтлэг татварын бус орлого	449,670.80	378,121.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	410,299.00	8,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,031,381.76	1,462,204.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,868.08	157,301.59
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,980,513.68	1,304,902.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,207,227.99	1,729,590.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,207,227.99	1,729,590.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,997.15	1,577,864.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,853.23	687,136.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,539.75	84,516.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,393.07	361,167.08
2104	Хангамж, бараа материалын зардал	53,300.26	53,745.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,260.70	41,127.35



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: О.Алтансүвд

Утас: 88009224

Цахим хаяг: altansuvdo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.01.24 № 345
Тайлан - ны № _____ - т

ОТГОН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТ-ОРГИЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд татвар болон татварын бус орлого 154,476.7 мянган төгрөгөөр, орон цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 207,317.5 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 106,433.5 мянган төгрөгөөр, улсын төсөвт байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт 17,580.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Отгон сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 390,014.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 581,035.2 мянган төгрөг буюу 148.9 хувиар давсан байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 22,159.7 мянган төгрөгийг 22 иргэнд буцаан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	787,146.32	752,757.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	527,286.70	553,887.87
33	АВЛАГА	204,632.75	86,391.17
35	БАРАА МАТЕРИАЛ	55,226.87	112,478.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	940,183.03	1,078,561.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	940,183.03	1,078,561.45
39200	Биет хөрөнгө	936,107.03	1,070,875.45
39300	Биет бус хөрөнгө	4,076.00	7,686.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,727,329.35	1,831,318.82
41360	Бусад өглөг	6,100.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,721,229.35	1,831,318.82
51	Засгийн газрын хувь оролцоо	1,721,229.35	1,831,318.82
51100	Засгийн газрын оруулсан капитал	782,776.19	782,776.19
51200	Хуримтлагдсан үр дүн	726,037.40	836,126.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,415.76	212,415.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,727,329.35	1,831,318.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,814,344.30	2,265,797.98
11	ТАТВАРЫН ОРЛОГО	333,291.74	425,471.70
110	Орлогын албан татвар	152,367.51	368,330.37
1100	Хувь хүний орлогын албан татвар	173,000.72	390,490.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,633.21	-22,159.73
113	Хөрөнгийн албан татвар	47,647.14	49,520.08
118	Бусад татвар, төлбөр, хураамж	133,277.10	7,621.26
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,057.62	3,603.57
1181	Газрын төлбөр	4,939.48	4,017.69
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	125,280.00	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	449,670.80	378,121.78
120	Нийтлэг татварын бус орлого	449,670.80	378,121.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	410,299.00	8,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,031,381.76	1,462,204.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,868.08	157,301.59
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,980,513.68	1,304,902.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,207,227.99	1,729,590.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,207,227.99	1,729,590.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,997.15	1,577,864.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,853.23	687,136.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,539.75	84,516.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,393.07	361,167.08
2104	Хангамж, бараа материалын зардал	53,300.26	53,745.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,260.70	41,127.35

2107	Томиллолт, зочны зардал	4,978.00	12,207.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,909.25	3,318.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	515,762.90	334,645.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,011,230.83	151,725.81
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	90,000.00	72,224.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	49,860.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	921,230.83	29,640.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	607,116.31	536,207.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	268,232.08	426,118.43
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	338,884.23	110,089.47

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	782,776.19	212,415.76	387,153.16	1,382,345.12
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	782,776.19	212,415.76	387,153.16	1,382,345.12
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	338,884.23	338,884.23
10	2023 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	782,776.19	212,415.76	726,037.40	1,721,229.35
11	2024 оны 1-р сарын 1-нэрэх үлдэгдэл	782,776.19	212,415.76	726,037.40	1,721,229.35
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	782,776.19	212,415.76	726,037.40	1,721,229.35
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	110,089.47	110,089.47
20	2024 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	782,776.19	212,415.76	836,126.87	1,831,318.82

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,457,940.30	2,043,239.79
11	ТАТВАРЫН ОРЛОГО	333,291.74	425,471.70
110	Орлогын албан татвар	152,367.51	368,330.37
1100	Хувь хүний орлогын албан татвар	173,000.72	390,490.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,633.21	-22,159.73
113	Хөрөнгийн албан татвар	47,647.14	49,520.08
118	Бусад татвар, төлбөр, хураамж	133,277.10	7,621.26
1181	Газрын төлбөр	4,939.48	4,017.69
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	125,280.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,266.80	155,563.59
120	Нийтлэг татварын бус орлого	93,266.80	155,563.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,990.45	118,596.22

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,031,381.76	1,462,204.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,868.08	157,301.59
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,980,513.68	1,304,902.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,085,378.38	1,575,070.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,085,378.38	1,575,070.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,147.55	1,423,344.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,443.93	684,866.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,189.20	84,516.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,237.60	360,646.99
2104	Хангамж, бараа материалын зардал	39,324.21	50,769.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,711.30	41,663.85
2107	Томилолт, зочны зардал	4,578.00	12,207.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,141.07	4,296.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	385,522.25	184,377.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,011,230.83	151,725.81
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	90,000.00	72,224.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	49,860.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	921,230.83	29,640.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	372,561.91	468,169.78
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	298,557.28	438,778.43
2200	Дотоод эх үүсвэрээр	298,557.28	438,778.43
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-298,557.28	-438,778.43
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-57,509.30	-2,790.18
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	57,509.30	2,790.18
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	16,495.33	26,601.17
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	510,791.36	527,286.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	527,286.70	553,887.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,036,742.10	1,778,593.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,370,675.60	1,343,584.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,320,815.00	1,293,724.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	688,507.60	684,866.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,516.00	84,516.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,839.80	357,322.23
2104	Хангамж, бараа материалын зардал	42,639.10	41,865.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,653.60	37,522.85
2107	Томилолт, зочны зардал	12,219.30	12,207.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,785.60	2,539.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,654.00	72,883.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,860.60	49,860.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,860.60	49,860.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	596,066.50	432,218.43

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.00	2,790.18
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,036,742.10	1,854,589.52
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,690,427.50	1,735,993.30
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	346,314.60	118,596.22
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	264,327.11
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	340,323.42

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31		/мянган төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,301.59	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,301.59	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,180.20	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,324.76	
210301	Гэрэл, цахилгаан	3,324.76	
2104	Хангамж, бараа материалын зардал	8,903.14	
210402	Тээвэр, шатахуун	7,861.64	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,041.50	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,701.00	
210604	Урсгал засвар	10,701.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,757.80	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,757.80	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,493.50	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,493.50	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,121.39	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,121.39	
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,121.39	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,301.59	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,301.59	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	157,301.59	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Отгон сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 67 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 80.6 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Отгон сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Отгон сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,989.47 төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	527,286.69	553,887.86	26,601.17
Авлага	204,632.75	86,391.17	(118,241.58)
Бараа материал	55,226.87	112,478.33	57,251.46
Үндсэн хөрөнгө	940,183.03	1,078,561.45	138,378.43
Нийт хөрөнгө	1,727,329.35	1,831,318.82	103,989.47
Өр төлбөр	6,100.00	-	(6,100.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,721,229.35	1,831,318.82	110,089.47
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,727,329.35	1,831,318.82	103,989.47

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 553,887.87 мянган төгрөг болж, өмнөх оноос мянган 26,601.17 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	527,286.70	553,887.87	26,601.17
Дүн	527,286.70	553,887.87	26,601.17

Эх сурвалж: Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 26,601.17 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн, ОНХС-ийн зарим ажил хийгдээгүйгээс үлдэгдэл өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 86,391.17 мянган төгрөг болж, өмнөх оноос 118,241.58 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	168.55	188.47	19.92
Хувь хүмүүсээс авах авлага	204,464.20	86,202.70	(118,261.50)
Дүн	204,632.75	86,391.17	(118,241.58)

Эх сурвалж: Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 118,241.58 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага барагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 112,478.33 мянган төгрөг болж, өмнөх оноос 57,251.46 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	52,825.22	110,076.68	57,251.46
Бичиг хэргийн материал	964.20	750.00	(214.20)
Аж ахуйн материал	3,225.18	3,759.18	534.00
Сэлбэг хэрэгсэл	180.00	700.00	520.00
Түлш, шатах тослох материал	3,288.64	4,562.40	1,273.76
Барилгын засварын материал	419.50	436.00	16.50
Бусад хангамжийн материал	44,747.70	99,869.10	55,121.40
Тусгай зориулалттай материал	2,401.66	2,401.66	-
Дүн	55,226.87	112,478.33	57,251.46

Эх сурвалж: Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 112,478.33 мянган төгрөгөөр өссөн нь Хандиваар өгсөн 69,609.8 мянган төгрөгийг аж ахуйн материалыг данс бүртгэлд тусгасан, тайлант онд 202,247.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 213,931.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 674.0 мянган төгрөгийн бараа материал акталсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой зөрчил илрээгүй байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Хур системд бүртгэлтэй ногоон байгууламжийн 4,180.0 мянган төгрөгийн газрыг данс бүртгэлд тусгасан.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,831,318.82 мянган төгрөг

болж, өмнөх оноос 103,989.47 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	936,107.03	1,070,875.45	134,768.43
Барилга, байгууламж, орон сууц	813,716.65	813,716.65	
Авто-тээврийн хэрэгсэл	238,326.80	444,416.69	206,089.89
Машин тоног төхөөрөмж(компьютер)	184,038.78	203,998.78	19,960.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	36,259.61	37,299.61	1,040.00
Бусад үндсэн хөрөнгө	277,324.00	307,324.00	30,000.00
Ном	3,543.58	3,543.58	
Биет бус хөрөнгө	4,076.00	7,686.00	3,610.00
Программ хангамж	3,437.00	3,437.00	
Бусад биет бус хөрөнгө	3,186.00	7,366.00	4,180.00
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(619,649.39)	(742,540.85)	(122,891.46)
Дүн	1,727,329.35	1,831,318.82	103,989.47

Эх сурвалж: Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 103,989.47 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,560.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 55,894.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, яамны хөрөнгө оруулалтаар 117,950.0 мянган төгрөгийн бусад байгууллагаас 74,305.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, тайлант оны элэгдлийн зардалд 122,891.46 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,100.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст төлөх өглөг	6,100.00		(6,100.00)
Бараа үйлчилгээний зардлын өглөг		-	
Ажилчидтай холбогдсон өглөг			
Дүн	6,100.00		(6,100.00)

Өр төлбөр өмнөх оны үлдэгдлээс 0.0 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүст төлөх өглөг 6,100.0 мянган төгрөг барагдсан барагдсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөртэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,831,318.82 мянган төгрөг болж, өмнөх оноос 103,989.47 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	782,776.19	782,776.19	
Өмч /гөрийн/ /ТӨҮГ/	782,776.19	782,776.19	-
Хуримтлагдсан үр дүн	726,037.40	836,126.87	110,089.47
Өмнөх үеийн үр дүн	387,153.16	726,037.40	338,884.23

Тайлант үеийн үр дүн	338,884.23	110,089.47	(228,794.76)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,415.76	212,415.76	-
Дүн	1,727,329.35	1,831,318.82	103,989.47

Эх сурвалж: Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 103,989.47 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 68 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 2,016,789.8 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,725,966.90 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 37 арга хэмжээг санхүүжүүлэхээр 769,200.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 367,551.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 290,823.0 мянган төгрөгийг Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс, 241,900.1 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 70,000.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс, 277,314.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2024 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 123,459.1 мянган төгрөгөөр буруулж, татварын болон татварын бус орлогыг 127,481.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс олгох Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардлыг 15,930.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2024 оны 10 сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 2,036,742.1 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 645,741.10 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 352,408.70 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 118,596.20 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 369,381.40 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 61,708.90 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 182,152.7 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 15,143.20 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	645,741.10	645,741.10	0.00
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	367,551.90	352,408.70	-15,143.20
3	Татварын болон татварын бус орлого	369,381.40	369,381.40	0.00
4	Урьд оны үлдэгдэл	277,314.60	61,708.90	-215,605.70
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	70,000.00	118,596.20	48,596.20
6	Улсын төсвийн байгууллагын тогтмол зардал	306,753.10	306,753.10	0.00
	ДҮН	2,036,742.1	1,854,589.4	182,152.7

Татварын болон татварын бус орлогоор 484,598.7 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 22,159.7 мянган төгрөгийг, санхүүжилтэд 369,381.40 мянган төгрөгийг олгож, 93,057.6 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,778,593.20 мянган төгрөг буюу 87.33 хувьтай байгаа нь Засаг даргын нөөц хөрөнгийг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүй зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	148,868.80	145,091.70	3,777.10	97.46
2	Засаг даргын Тамгын газар	915,053.70	900,259.20	14,794.50	98.38
3	Орон нутгийн хөгжлийн сан	596,066.50	432,218.40	163,848.10	72.51
4	Хоршоо хөгжүүлэх сан	70,000.00	2,790.10	67,209.90	3.99
5	Улсын төсвийн байгууллагын тогтмол зардал	306,753.10	298,233.80	8,519.30	97.22
ДҮН		2,036,742.10	1,778,593.20	258,148.90	87.33

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2024 онд нэмэлт санхүүжилтээр 157,301.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 136,180.2 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, шуудан, холбоо интернэтийн төлбөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, багаж техник хэрэгсэл, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үечилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, үлдэгдэл 21,121.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. *Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.*

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгон сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Отгон сумын Засаг дарга нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 1/43 дугаартай албан тоотгоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,722,140.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,832.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,374.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Отгон сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, зөвлөмж өгөгдөөгүй, дотоод хяналттай холбоотой 87,121.5 мянган төгрөгийн зөрчилд аймгийн Засаг даргад хариуцлага тооцох албан шаардлага өгч, хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Хариуцлага тооцох албан шаардлага	1	179,295,5	1	179,295,5	100%
Нийт дүн	1	179,295,5	1	179,295,5	100%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцоулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

Огноо: 2025-03-25

АТААЛ
99.1

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



О.АЛТАНСУВД

Огноо: 2025-03-25